

Алтайн Урианхайн хошуунуудаас Жавзандамба хутагт, Их хүрээ зэрэг бусад сүм хийдэд мөргөл үйлдэж байсан тухай түүхийн баримтууд

Ондрей Срба (Ondřej Srba), БНЧУ-ын Масарикийн Их Сургууль
Masaryk University, Faculty of Arts, Department of Mongolian, Korean and Vietnamese Studies

“Монголын нүүдэлчин малчдын дасан зохицох арга барилын хувирал өөрчлөлт: Нутгийн түүх болон нүүдэл суудлын хэвшил хувиралтыг аман сурвалжаар баримтжуулах нь”

“Changing Adaptive Strategies of Mobile Pastoralists in Mongolia: Dynamics in Community Histories and Movement Patterns Documented Through Oral Sources” (Czech Science Foundation, JUNIOR STAR GM23-07108M) төслийн хүрээнд бэлтгэв.

Алтайн Урианхайн долоон хошуу

- 1754/1755 оны үед Манж Чин улсад дагаар орсноор Алтайн Урианхайн долоон хошууны зохион байгуулалт бүрэлдэж эхлэв.
- 1762/1763 оны үед Алтайн Урианхайн хоёр сул амбанаар зүүн баруун хоёр гарын зохион байгуулалт батлагдаж, хоёр тамга олгогдов.
- 1771 Алтайн Урианхайн долоон хошуу Ховдын сайдад харьяалагдав.



1906 онд Алтайн Урианхайн Баруун Амбаны хүрээний лам нар (В.В.Сапожниковын зураг)

Алтайн Урианхайчуудын мөргөхөөр явах тухай гол эх сурвалжууд

- БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив, Цэргийн Тухай Газар, улаан бийрээр цохсон айлтгалын бичгүүд 軍機處滿文錄副奏摺
- МУ Үндэсний Төв Архив, М-1, Хүрээнд сууж хэрэг шийтгэгч манж сайдын яам (мөргөхөөр ирсэн хүмүүст зам явах тэмдэгт бичиг олгох тухай нугалбар, хуулбар дансууд)
- МУ ҮТА, М-87 Жавзандамба хутагтын дотоод сан – орлого зарлагын бүгдийн дансууд (мөнгө цайны орлого данс)

Урьдчилсан статистикийн мэдээлэл

Дээрх сурвалжууд дээр үндэслэн Манж Чин улсын үед Алтайн Урианхайн 7 хошуунаас

- Их хүрээнд (Жавзандамба хутагтад):
 - 1796–1866 онд 8-83 хүний бүрэлдэхүүнтэй 11 удаагийн томоохон аялал
- Утай ууланд:
 - 1806, 1828, 1847 онд 9-20 хүний бүрэлдэхүүнтэй 3 удаагийн томоохон аялал
- Гүмбүм хийдэд:
 - 1900 онд 20 хүний бүрэлдэхүүнтэй 1 удаагийн томоохон аялал

он	хошуу	хошууны ноён	мөргөлчдийг удирдсан хүн	явсан хүний тоо	Ховдын амбанаас Цэргийн тухайн газарт айлтгал өргөсөн огноо	Цэргийн тухайн газраас айлтгасан огноо	БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив дахь эх сурвалжийн хадгаламжийн нэгж
1796	АУ Зүүн амбаны х.	сул амбан Буяндэлэг	Буяндэлэгийн эх Дэлдэн, сумын занги Дагва	20 хүн		СЕ 1.6.5. (1796.7.9.)	03-0196-3543-030
1808	АУ Зүүн амбаны х.	сул амбан Буяндэлэг	Буяндэлэгийн эх Ишюмчин, сумын занги Дагва	75 хүн	СЕ 13. илүү 5.18. (1808.7.11.)	СЕ 13.6.4. (1808.7.26.)	03-0198-3743-031
1808	АУ Баруун амбаны х.	сул амбан Моломдаржаа, бүгдийн дарга Пүрэвцэрэн	Моломдаржаагийн хошууны гэлэн Чойндүн, Пүрэвцэрэнгийн хошууны занги Чоно	Чойндүний 46 хүн, Чонын 37	СЕ 13.4.25. (1808.5.20.)	СЕ 13.5.13. (1808.6.6.)	03-0198-3739-024

1812 заланы занги Сономдаржаагийн аялал

- АУ Баруун амбаны хошууны сул амбан Моломдаржаагийн харьяат заланы занги Сономдаржаа, лам хар нийт 32 хүн
- Сайшаалт Ерөөлтийн 17.6.19. (1812.7.27.) Ховдын амбанаас Хүрээний сайдад зориулсан зам явах тэмдэгт бичгийг олгов (М-1, Д-2, ХН-273)
- СЕ 17.6.20 (1812.7.28.) нутгаасаа хөдөлсөн
- СЕ 17.9.9. (1812.10.13.) Ховдын амбанаас айлтгасан айлтгал Цэргийн тухайн газарт хүргэгдэв
- СЕ 17.9.24. (1812.10.28.) Цэргийн тухайн газраас айлтгаад улаан бийрээр цохуулав (БНХАУ ТНА 03-0199-3821-040)

1812 заланы занги Сономдаржаагийн аялал

- унах морь 80, ачих тэмээ 40, авч явах буу хоёр, саадаг хоёр иж
- Сономдаржаагийн биеэс гадна бошго Дагандай, цэрэг Хаян, Цэндэн, Илчай, Бичихар, Орших, Хонхор, Эбүжү?, Шэрэн, Түвдэн, Хонходай, Тосон, Дорж, Хүүхэн, Эрэлда, Халдай, Өмхий;
- лам: Лувсан, Гончиг, Дагва, Лувсан, Баян (Баянг), Чойдаржаа, Лувсан, Балдан, Түвдэн, Жимба; эм: Янжинжав, Хүхүй, Хэшиг, Халиун гэх нэртэй хүний жагсаалт

он	хошуу	хошууны ноён	мөргөлчдийг удирдсан хүн	явсан хүний тоо	Ховдын амбанаас Цэргийн тухайн газарт айлтгал өргөсөн огноо	Цэргийн тухайн газраас айлтгасан огноо	БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив дахь эх сурвалжийн хадгаламжийн нэгж
1821	АУ Зүүн амбаны х., Мянгад х.	сул амбан Буяндэлэг, бүгдийн дарга Чуй	Буяндэлэгийн хошууны занги Мягмар, Чуйн хошууны ловон лам Самдан	Мягмарын 17 хүн, Самданы 15 хүн	ТГ 1.11.21. (1821.12.15.)	ТГ 1.12.10. (1822.1.2.)	03-0201-3966-016

1831 АУ Зүүн гарын сул амбан Буяндэлэгийн аялал

- Буяндэлэгийн хошууны лам хар нийт 30 хүн (сул амбан Буяндэлэг (1789-1838 онд хошууг захирав), авгай Аги, залан Азар (ajara), Буяндэлэгийн хөвүүн Рашаан, лам арав, хар арван зургаан хүн); сул амбан Буяндэлэг тамгаа тус гарын бүгдийн дарга Гүржавд түр хамааруулав
- Дөрвөдийн чуулганы чуулганы да гүн Норовын аймгийн бэйл Базарзанын хошууны да лам Балданчоймбол, мэйрэн Чагдаржав, лам хар нийт 25 хүн
- *тэдний унах морь 90, ачих тэмээ 50, авч явах буу 2, саадаг 1 иж, монгол гэр 1, майхан 4 (М-1, Д-1, ХН-3931, Н-2, Н-3, Н-5, Н-12)*

1831 АУ Зүүн гарын сул амбан Буяндэлэгийн аялал

- Төр Гэрэлтийн 11.5.25. (1831.7.4.) Ховдын сайдаас айлтгасан айлтгалд “нутгаасаа 6 сарын шинэдээр замд гарна” (1831.7.9.-17.)
- ТГ 11.6.12. (1831.7.20.) Ховдын амбанаас Цэргийн тухайн газарт өргөсөн айлтгал хүргэгдэв
- ТГ 11.6.25. (1831.8.2.) Цэргийн тухайн газраас айлтгав (БНХАУ ТНА 03-0202-4103-041)
- ТГ 11.7.8. (1831.8.15.) улаан бийрээр цохсон
- ТГ 11.7.14. (1831.8.21.) улаан бийрээр цохсон явдлыг Ховдын амбанаас Хүрээний сайдад мэдүүлсэн
- ТГ 11.8.25. (1831.9.30.) Хүрээний сайдаас буцах замд явах тэмдэг бичгийг олгов

1832 АУ Баруун гарын сул амбан Моломдаржаагийн аялал

- Моломдаржаа (1781-1836 онд хошууг захирав) “миний бие эмгэгтэй тул” Жавзандамба хутагтад мөргөхөөр явав, нийт 70 хүн
- тамгыг өөрийнхөө хоёрдугаар хөвгүүн, заланы занги Дашзэгвэд түр хамааруулав

1832 АУ Баруун гарын сул амбан Моломдаржаагийн аялал

- ТГ 12.1.25. (1832.2.26.) Моломдаржаа Ховдын амбанаас зам явах тэмдэг бичиг олгохыг хүсэв
- ТГ 12.3.шинэдээр (1832.4.1.-9.) нутгаас гарав
- ТГ 12.4.6. (1832.5.5.) Ховдын амбанаас мөргөлчдийн ирэхийг мэдүүлсэн явдлыг Хүрээний сайдаас Шанзудбын яаманд анхааруулж байна
- ТГ 12.5.4. (1832.6.2.) Ховдын амбанаас Цэргийн тухайн газарт өргөсөн айлтгал хүргэгдэв
- ТГ 12.5.19. (1832.6.17.) Цэргийн тухайн газраас айлтгаад улаан бийрээр **ЦОХУУЛАВ** (БНХАУ ТНА 03-0202-4115-014), (Их хүрээний сайдад ирсэн хуулбар: М-1, Д-1, ХН-3948, Н-26)

1832 АУ Баруун гарын сул амбан Моломдаржаагийн аялал

- Жавзандамба хутагтыг Их Хүрээний газраа бус, Амарбаясгалант хийдэд саатаж байсан тул, Моломдаржаа Их Хүрээнд оролгүй шууд Амарбаясгалант хийд очоод, тэндээс хөсөг, ачаа ихтэй тул нэгмөсөн буцсан ба хүн зарж Их Хүрээнээс шинэ зам явах тэмдэгт бичгийг авхуулсан явдлыг Шанзудбын яам, Их хүрээний сайд нараас сийрүүлэн мэдээлэв ТГ 12.8.14./18. (1832.9.8./12.)
- М-1, Д-1, ХН-945, х.15r-v, М-1, Д-1, ХН-3948, Н-9, Н-19, 20

он	хошуу	хошууны ноён	мөргөлчдийг удирдсан хүн	явсан хүний тоо	Ховдын амбанаас Хүрээний сайдад илгээсэн огноо	Ховдын амбанаас Цэргийн тухайн газарт айлтгал өргөсөн огноо	Цэргийн тухайн газраас айлтгасан огноо	Хүрээний сайдаас буцах замд явах тэмдэг бичиг олгосон тухай нугалбарын огноо	Тэмдэглэл	БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив дахь эх сурвалжийн хадгаламжийн нэгж	МУ-ын ҮТА дахь холбогдох эх сурвалж
1835	Торгууд, АУ Баруун амбаны х.	Торгуудын бэйс Цэрэндорж, АУ Баруун гарын сул амбан Моломдаржаа	Торгуудын бэйс Цэрэндорж, АУ Баруун амбаны хошууны заланы занги Дашзэгвэ	лам хар 50 хүн, лам хар 20 хүн	<i>нутгаас замд гарав</i> ТГ 15.5.20. (1835.6.15.) Хүрээний сайдаас Эрдэнэ Шанзудбын яаманд ТГ 15.6.22. (1835.7.17.)-нд хүрч ирэхийг хүлээж байна гэж мэдүүлсэн	ТГ 15.6.6. (1835.7.1.)	ТГ 15. илүү 6.21. (1835.8.15.)	ТГ 15. илүү 6.7. (1835.8.1.) <i>буцах замд гарна гэж мэдүүлсэн</i> ТГ 15. илүү 6.13. (1835.8.7.) Хүрээний сайдын газраас буцах замд явах тэмдэгт бичиг олгосныг Ховдын сайдад мэдүүлэв	бэйс Цэрэндоржийн барьсан тамгыг туслагч Чойжинжавд түр хамааруулав	03-0203-4155-026	М-1, Д-1, ХН-990, х. 281г-v
1840	АУ Баруун амбаны х.	АУ Баруун гарын сул амбан Дашзэгвэ	тус хошууны бошго Өсгөлөн (bošukû ūskulung)	нэг бүлэг лам хар 10 хүн		ТГ 20.6.26. (1840.7.24.)	ТГ 20.7.10. (1840.8.7.)			03-0203-4210-017 (002204-002206)	

он	хошуу	хошууны ноён	мөргөлчдийг удирдсан хүн	явсан хүний тоо	Ховдын амбанаас Хүрээний сайдад илгээсэн огноо	Ховдын амбанаас Цэргийн тухайн газарт айлтгал өргөсөн огноо	Цэргийн тухайн газраас айлтгасан огноо	Хүрээний сайдаас буцах замд явах тэмдэг бичиг олгосон тухай нугалбарын огноо	БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив дахь эх сурвалжийн хадгаламжийн нэгж	МУ-ын ҮТА дахь холбогдох эх сурвалж
1856	Захчин гүний хошуу	Захчины гүн Минжүүрдорж (minjuurdorji), АУ Баруун гарын сул амбан Санжмятав (sanjimidub)	гүн Минжүүрдорж, Санжмятавын хошууны сумын занги Нямаа (nirui janggin nima)	Минжүүрдоржийн 58 хүн, Нямаагийн 9 хүн	<i>нутгаас зам гарна</i> ТЭ 6.7.9. (1856.8.9.) Халхын Зая бандидын хүрээнд ирээд Жавзандамба хутагтын хүрээний эргэнд өвчин тархсан тул зогсоогдож нутаг буцаагдлаа	ТЭ 6.9.16. (1856.10.14.)	ТЭ 6.10.2. (1856.10.30.)	ТЭ 6.10.7. (1856.11.4.) нутагтаа эргэж ирэв ТЭ 6.11.18. (1856.12.15) Ховдын амбанаас тэдний зам явах тэмдэгт бичгийг хураагаад эвдсэн явдлыг Хүрээний сайдад мэдүүлэв	03-0207-4410-032 (001385-00187)	М-1, Д-1, ХН-1353, х. 229

1866 АУ Баруун гарын сул амбан Аюушийн аялал

- АУ Баруун гарын сул амбан Аюуш зэрэг 8 хүн
- “унах ачих тэмээ хорин, унах морь хоёр, монгол гэр нэг, майхан нэг, буу нэг, саадаг нэг иж” (М-1, Д-1, ХН-1542, х. 78r-79r)
- БЗ 5.3.18. (1866.5.2.) Ховдын амбанаас Цэргийн тухайн газарт өргөсөн айлтгал хүргэгдэв
- БЗ 5.4.2. (1866.5.15.) Цэргийн тухайн газраас айлтгав (БНХАУ ТНА 03-82-4683-047)
- БЗ 5.4.19. (1866.6.1.) Хүрээний сайдын газраас буцах замд явах тэмдэгт бичгийг олгов
- БЗ 5.4.20. (1866.6.2.) нутаг буцах замд гарав

M-87, Д-1, ХН-428

1. амбан Аюуш
2. гэлэн Самдан
3. Данзан
4. занги Хэт?
5. Цэрэн
6. Дорж
7. Жамба
8. Булдар

Handwritten Mongolian script on a rectangular piece of paper. The text is arranged in several vertical columns, with some characters appearing to be in a different script or dialect. The paper shows signs of age and wear.

Handwritten Mongolian script on a rectangular piece of paper. The text is arranged in several vertical columns, with some characters appearing to be in a different script or dialect. The paper shows signs of age and wear.

Handwritten Mongolian script on a rectangular piece of paper. The text is arranged in several vertical columns, with some characters appearing to be in a different script or dialect. The paper shows signs of age and wear.


Утай ууланд мөргөхөөр явсан тухай



Handwritten text in Mongolian script, likely a historical document or letter, written vertically on a piece of paper. The text is arranged in several columns, with a large character '理' (Li) visible on the right side.

он	хошуу	хошууны ноён	мөргөлчдийг удирдсан хүн	явсан хүний тоо	Ховдын амбанаас Цэргийн тухайн газарт айлтгал өргөсөн огноо	Цэргийн тухайн газраас айлтгасан огноо	БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив дахь эх сурвалжийн хадгаламжийн нэгж
1806	АУ Баруун амбаны х.	сул амбан Моломдаржаа, бүгдгийн дарга Түвд	[Моломдаржаагийн хошууны] хошууны жинхэнэ да лам Зундуйжамба (jingkini da lama junduijamba); [Түвдийн хошууны] жинхэнэ да лам гэлэн Чурумбалдан (gelung curumbaldan)	Зундуйжамба зэрэг 12 хүн; Чурумбалданы зэрэг 8 хүн	СЕ 11.7.7. (1806.8.20.)	СЕ 11.7.21. (1806.9.3.)	3-0197-3704-54 (003417-003420)
1828	АУ Баруун амбаны х.	сул амбан Моломдаржаа	хошууны жинхэнэ да лам Даржаа	есөн хүн	ТГ 8.10.16. (1828.11.22.)	ТГ 8.11.минэд (1828.12.7.-15.)	3-0202-4064-056
1847	АУ Зүүн амбаны х.	сул амбан Дармаазар, Халхын жасаанд суух засгийн тамгыг хамаарсан туслагч тайж Дугаржав	Дармаазарын эх Дулмаа зэрэг арван долоон хүн лам Жанцан зэрэг лам хар зургаан хүн	Дулмаа зэрэг арван долоон хүн, Хонгорөлөнгийн өртөөний цэрэг лам Жанцан зэрэг лам хар зургаан хүн	ТГ 27.10.7. (1847.11.14.)	ТГ 27.10.10. (1847.11.27.)	3-205-4898-28

Гүмбүм хийдэд мөргөхөөр явсан тухай



он	хошуу	хошууны ноён	мөргөлчдийг удирдсан хүн	явсан хүний тоо	Ховдын амбанаас Цэргийн тухайн газарт айлтгал өргөсөн огноо	Цэргийн тухайн газраас айлтгасан огноо	БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив дахь эх сурвалжийн хадгаламжийн нэгж
1900	АУ Баруун амбаны х.	сул амбан Сайнбилэг (saimbeleg)	Сайнбилэгийн гэргий Мэнджаргал, төрсөн хөвүүн хамба лам хийгээд орлосон хүнд	лам хар бүгд 20 хүн	БД 25.12.17. (1900.1.17.)	БД 26.1.13. (1900.2.12.)	03-0210-4575-19 (003134-003137)

Дүгнэлт

Дээр танилцуулсан баримтын үндсэн дээр, Алтайн Урианхайн долоон хошуунаас 18-р зууны сүүлээс 20-р зууны эхэн хүртэл Халхын Их Хүрээ болон Жавзандамба хутагт, Утай уул, Гүнбүм хийдэд мөргөхөөр очих холын аян удаа дараа зохион байгуулагджээ.

Баруун хязгаараас Жавзандамба хутагтад мөргөхөөр ирж байсан энэхүү хөдөлгөөн Халхаас бусад, Монгол орны алслагдмал нутагт Жавзандамба хутагтад хандах сүсэг бишрэлийн тухай гэрчилж буй. Зуу гаруй жилийн хугацаанд Алтайн Урианхайчууд Их хүрээ, Жавзандамба хутагтыг итгэлийн орон хэмээн шүтэж явсны үр дүнд 1912 онд тэд тусгаар тогтносон Монголын төрд нэг санаагаар дагаар оржээ.